

ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА, МЭДЭЭЛЛИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн үндэслэл, шаардлага

Эрх зүйн сургалт, сурталчилгаа мэдээллийг тасралтгүй явуулах нь төрийн хууль тогтоомжоор бүх шатны ИТХ, Засаг даргад хуулиар хүлээлгэсэн орон нутагт төрийн хууль тогтоомжийн бодит биелэлтийг хангах үүргийг хэрэгжүүлэх чухал хүчин зүйлийн нэг юм.

Нийгмийн харилцааг зохицуулсан олон хууль, эрх зүйн актууд шинээр батлагдаж, мөн богино хугацаанд өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа өнөөгийн нөхцөлд иргэдийн эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг шуурхай, хүртээмжтэйгээр олон нийтэд хүргэх, эрх зүйн сурталчилгаа, мэдээллийн ажлыг орчин үеийн техник, технологийн дэвшлийг ашиглан эрчимжүүлэх шаардлага үүсээд байна.

Түүнчлэн нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөж хэрэгжүүлбэл зохих аймгийн ИТХ, Засаг даргаас батлан гаргасан шийдвэрийг тайлбарлан таниулж сурталчлах нь бүрэн эрхийн хугацаанд дэвшүүлсэн зорилтоо хэрхэн хангаж байгааг иргэд олон нийтэд таниулах нэг арга зам болох юм.

Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, эрх зүйн хэрэглээний мэдлэг олгох хэвлэлийн нийтлэл, телевизийн нэвтрүүлгийг тодорхой бодлого, төлөвлөгөөний дагуу хийж хэвшүүлэх шаардлагатай байна.

Өнгөрсөн хугацаанд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэйгээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас аймгийн төв, болон Булган суманд Эрх зүйн туслалцааны төв байгуулсан ба иргэдийн мэдээлэл хүлээж авах насны онцлог, сонирхол, зэргээс хамааран олон нийтийг зорилтот бүлгүүдэд хувааж эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг зохион байгуулж, бүх суманд эрх зүйн ажилтны орон тоо бий болгож, мэргэжлийн боловсон хүчнээр хангасан нь иргэдэд хүргэх эрх зүйн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, төрийн албаны үйл ажиллагаанд хууль хэрэглэх мэдлэг хандлага,

удирдлагын шийдвэрийн хууль зүйн үндэслэл соёл дээшлэхэд зохих нөлөө үзүүлсэн.

Мөн Хууль зүй дотоод хэргийн яамнаас сум бүрт эрх зүйн хөтөч/ ухуулагч/-ийг сурган бэлтгэж арга зүйн сургалтуудад хамруулж байсан боловч сумдад тэдгээрийг ашиглан хууль тогтоомжийг иргэд олон нийтэд тайлбарлан таниулах, иргэдийн хэрэгцээ шаардлагыг судлан эрх зүйн мэдээлэл сурталчилгаагаар хангах ажил шаардлагын хэмжээнд явагдаагүй байна.

Иргэдийн эрх зүйн мэдлэг хангалтгүй, төр, хуулийн байгууллага, тэдгээрийн үйл ажиллагаа, ажилтнуудын талаарх буруу үнэлэмж, төсөөлөл зэрэг нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад сөрөг нөлөөлөл үзүүлдэг нэг хүчин зүйл болж байна.

Олон нийтийн эрх зүйн ухамсар, хэрэглээний соёлыг бүрдүүлэх нь дан ганц боловсролын системээр дамжин хэрэгжүүлэх боломжгүй зорилт бөгөөд үүнд хэвлэл мэдээллийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагууд, нутгийн захиргааны байгууллага болон аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэх, эрх зүйн сургалт сурталчилгааны дэд бүтцийг бий болгох замаар эрх зүйн сурталчилгаа, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх нь чухал ач холбогдолтой.

Түүнчлэн аймаг, сумдад шинээр байгуулагдаж байгаа "Иргэний танхим"-аар дамжуулан шинээр гаргах хууль тогтоомж, ИТХ, Засаг даргын шийдвэрийн төслийг иргэдээр хэлэлцүүлэн тэдний саналыг тусгах, орон нутгийн хөгжлийн асуудалд иргэдийн оролцоог хангах бодлого зорилтыг хэрэгжүүлэхэд энэхүү хөтөлбөр зохих үүрэг гүйцэтгэх юм.

Хоёр. Хөтөлбөрийн эрх зүйн орчин

Төрөөс иргэдийн эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, албан бус сургалтыг дэмжих зорилгоор бодлогын шинж чанартай баримт бичиг, шийдвэрүүдийг удаа дараа гаргасаар ирсэн бөгөөд дараах хууль тогтоомж, УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоолууд болон эрх бүхий байгууллагуудын шийдвэр үүнд хамаарагдаж байна. Үүнд:

- Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9-д заасан " иргэдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ажлыг зохион байгуулж, хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг тайлбарлан таниулах" ИТХ-ын Тэргүүлэгчдийн бүрэн эрх,

- Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн тухай 29 дүгээр зүйлийн 1.6-ын “а”-д заасан “...хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах”, 29 дүгээр зүйлийн 1.6-ын “е” –д заасан “ ...нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын үйл ажиллагааны талаар хүн амыг үнэн зөв мэдээллээр хангах” Засаг даргын бүрэн эрх

-Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр батлах тухай УИХ-ын 1998 оны 18 дугаар тогтоол;

-Эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг сайжруулах тухай Засгийн газрын 1993 оны 57 дугаар тогтоол;

-Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 1996 оны 66 дугаар тогтоол;

-Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр хамтран ажиллах тухай Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улын Дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгчийн хамтарсан 2003 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 252/824/456/68 тоот тушаал, захирамж;

-Төрийн мэдээлэл эмхтгэлийг захиалж байх тухай Засгийн газрын 2004 оны 11 дүгээр тогтоол байна.

-Шинэчилсэн Засгийн газрын үйл ажиллагааны болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох зорилт зэрэг болно

Гурав. Хөтөлбөрийн зорилго

Иргэдийн бодит хэрэгцээ, орчин үеийн арга зүй, төрийн болон олон нийтийн байгууллага, хэвлэл мэдээлийн хэрэгслийн хамтын ажиллагаа, олон нийтийн идэвх, оролцоонд суурилсан эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааны тогтолцоог бүрдүүлэх, иргэдийн эрх зүйн ухамсрыг зөв төлөвшүүлж, нийгмийн үнэт зүйлсийн үнэлэмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн хүртээмжтэй, чанартай, үр нөлөөтэй мэдээлэл сурталчилгааг зохион байгуулах нь хөтөлбөрийн гол зорилго мөн.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилтууд

Хөтөлбөрийн зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудын хүрээнд холбогдох үйл ажиллагааны хэрэгжилтийг тодорхой төлөвлөгөөний дагуу зохион байгуулах. Үүнд:

Зорилт 1. Судалгааны үндсэн дээр иргэдийг насны онцлог, сонирхол, хэрэгцээг харгалзан зорилтот бүлгүүдэд хуваах, бүлэг тус бүрийн хэрэгцээнд нийцсэн нийгмийн үнэт зүйлсийг төлөвшүүлэх тэргүүлэх чиглэлтэй хослуулан хүргэх эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллийн төлөвлөгөө, үр дүнг тооцох аргачлалыг боловсруулах, эрх зүйн сурталчилгаа, мэдээллийн ажлыг зохион байгуулах бүтэц, тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд:

1.1. Иргэдийн эрх зүйн мэдээллийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсоны үндсэн дээр зорилтот бүлэг болгоны хэрэгцээнд нийцсэн дэд хөтөлбөр арга зүй гарын авлага боловсруулах, эрх зүйн сурталчилгааны ажлын үр дүнг бодитой дүгнэх аргачлалтай болох.

1.2. Эрх зүйн сурталчилгаа, мэдээллийн ажлыг зохион байгуулах бүтцийг боловсронгуй болгох

1.3. Иргэдэд зориулсан эрх зүйн мэдлэг олгох сургалтуудын хөтөлбөр бий болгож сум, багт хүргэх

Зорилт 2. Эрх зүйн сурталчилгаа, мэдээллийн ажлын арга зүйг боловсронгуй болгож, иргэдэд хүртээмжтэй, чанартай, сурталчилгаа, мэдээллийг энгийн ойлгомжтой, орчин үеийн шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулах ажлын хүрээнд:

2.1. Мэдээллийн технологийг эрх зүйн сургалт, сурталчилгаанд түлхүү нэвтрүүлэх

2.2. Эрх зүйн сэдвээр хэвлэж байгаа гарын авлага, ном, товхимолыг ойлгоход хялбар, нийгмийн тодорхой зорилтот бүлгүүдэд зориулан хэвлэн тараах ажлыг зохион байгуулах.

2.3. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, Хүний эрхийг хангах хамгаалахад чиглэсэн төрийн бодлого шийдвэр, хууль сурталчлах, нийгмийн үнэт зүйлсийг сурталчлахад чиглэгдсэн олон нийтийг хамарсан ажлыг зохион байгуулах

Зорилт 3. Эрх зүйн сургалт, сурталчилгааг орон нутагт хүргэх дэд бүтцийг боловсронгуй болгох, орон нутгийн засаг захиргааны байгууллага болон Эрх зүйн мэдээлэл сурталчилгааны төвүүд, иргэний танхимын оролцоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд:

3.1 Сумдад ажиллах эрх зүйн мэдээллийн төв болон иргэний танхимын зорилго, үйл ажиллагааг уялдуулах

3.2 Эрх зүйн сургалт, сурталчилгааны дэд бүтцийг бий болгож баг бүрт эрх зүйн бичил номын сан бий болгох .

3.3 Эрх зүйн хөтөч /ухуулагч/-ийг үр нөлөөтэй ажиллуулах.

Зорилт 4. Эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг зохион байгуулахад иргэд, аж ахуйн нэгж, хэвлэл мэдээллийн болон олон нийтийн, төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг тогтвортой хөгжүүлэх ажлын хүрээнд:

4.1. Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран эрх зүйн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.

4.2. Аж ахуйн нэгж байгууллагууд, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах.

Дөрөв. Хөтөлбөрийн тэргүүлэх чиглэл

Эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг нь хоорондоо харилцаа холбоо бүхий дараах тэргүүлэх чиглэлтэй уялдуулан хэрэгжүүлэх. Үүнд:

4.1. Эрх зүйн сурталчилгааг боловсронгуй болгохын тулд орон нутгийн эрх зүйн сурталчилгаа, мэдээлэл хариуцсан албадыг бэхжүүлж, орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангах, хүний нөөцийг чадавхижуулах, эрх зүйн сургалт, сурталчилгааны арга зүйн шинэлэг хэв маяг, шалгуур үзүүлэлт бүхий тогтолцоог бий болгох;

4.2. Архигүй, амгалан тайван, хүчирхийллээс ангид орчныг бүрдүүлэхийн төлөө иргэд, залуучуудын ухамсрыг дээшлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, ухуулан сурталчлах, таниулах ажлыг өрнүүлэн Гэмт хэргээс урьчилан сэргийлэх салбар зөвлөлүүдтэй хамтран ажиллах;

4.3. Иргэд эрх, үүргээ ухамсарлах, хууль ёсны ашиг сонирхолоо хамгаалах, амьдралын зөв хэв маягийг сонгох, төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, авлигагүй нийгэмд амьдрахыг эрмэлзэхэд чиглүүлэх, шударга ёс, гэр бүл, эрүүл мэнд, спорт, хөдөлмөр, байгаль хамгаалах, эрүүл нийгэм зэрэг нийгмийн үнэт зүйлсийг олон нийт, ялангуяа өсвөр үеийхэн, залуучуудад тайлбарлан таниулах, сурталчлах замаар иргэний ухамсрыг дээшлүүлэх;

4.4. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, ухамсрыг төлөвшүүлэх, хууль тогтоомжийг олон нийтэд тогтмол шуурхай сурталчилах, тайлбарлан таниулах ажлыг эрчимжүүлэх чиглэлд хууль сахиулах байгууллагуудын болон төрийн албан хаагчдын хүчийг нэгтгэх, эрх зүйн сурталчилгаа, мэдээллийн ажлыг хамтран чанартай, хүртээмжтэй арга хэлбэрээр зохион байгуулах, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн

байгууллагуудыг эрх зүйн сурталчилгаанд татан оролцуулах ажлыг өргөн цар хүрээтэйгээр зохион байгуулах юм.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа:

5.1. Хөтөлбөрийн 2013-2016 онд Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

6.1. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

6.1.1. Төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн төлөөлөл бүхий салбар хоорондын орон тооны бус зөвлөл нь хөтөлбөрийг бодлогын удирдлагаар хангаж хэрэгжилтэд хяналт тавина;

6.1.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх өдөр тутмын ажлыг ИТХ-ын Нутгийн удирдлага, хууль зүйн хэлтэс болон аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс, Эрх зүйн туслалцааны төв хариуцан зохицуулна.

6.1.3. Хөтөлбөрийг суманд хэрэгжүүлэх ажлыг сумын ИТХ-ын ажлын алба, Засаг даргын Тамгын газар, багт багийн Засаг дарга хариуцан гүйцэтгэнэ

6.2. Хөтөлбөрийн санхүүжилт

6.2.1. Улсын төсөв

6.2.2. Орон нутгийн төсөв

6.2.3. Олон улсын байгууллага, гадаадын дотоодын төслийн санхүүжилт

6.2.4. Хуулиар зөвшөөрсөн бусад эх үүсвэр

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад олон нийтийн санал асуулга, социологийн судалгаа, хөтөлбөрийн явцад боловсруулагдах шалгуур үзүүлэлт, үр дүнг тооцох аргачлалын дагуу дүгнэж цаашдын бодлого чиглэлийг тодорхойлно.

Найм. Хөтөлбөрөөс хүлээгдэж буй үр дүн

8.1. Эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлын агуулга, арга зүйг зөв тодорхойлж, иргэдийн бодит хэрэгцээнд нийцүүлэн зохион байгуулах чадвар бүхий эрх зүйн сургалт, сурталчилгааны тогтолцоо болон хүний нөөцтэй болсон байна.

8.2. Эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг зөв оновчтой зохион байгуулснаар иргэдийн хууль, эрх зүйн анхан шатны мэдлэгийн түвшин дээшилсэн байхын зэрэгцээ иргэд нийгмийн харилцаанд ухамсартай, хариуцлагатай оролцох, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үнэт зүйлсийн талаархи зөв төлөвшлийг олгох, хөгжүүлэхэд ахиц гарсан байна.

----- оОо -----